



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.24 № 03/15 ЧАГ-САГ/2014/63/СТГА-ТӨЧГ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ Я.ПҮРЭВЖАВ
ТАНАА

Зөрчлийг арилгуулах тухай

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дуусгавар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тус төв нь тайлант хугацаанд бэлэн мөнгөөр гарсан нотлох баримт дутуу 14,144,778.00 төгрөг, анхан шатны баримтгүй 24,646,849.00 төгрөгийн зарлагын гүйлгээг гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д заасан “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”, 7 дугаар зүйлийн 7.4-т “Аж ахуй нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ”, 7.7-т “анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно,” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцат илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

Дээрх бэлэн мөнгөөр гарсан зарлагын нотлох баримтыг холбогдох ажилтнуудаас гаргуулан авч зөрчлийг арилгаж, биелэлтийг 2014 оны 06 сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг ТӨААТҮГ-ийн Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Түвшинтөгсд даалгав.

ШИНЖЭЭЧ



Н.НЯМДАВАА